



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/223

Улаанбаатар хот

Дүүргийн архивын баримтыг цахим
хэлбэрээр хадгалахад зориулан
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн архивын тусгай төрлийн баримтыг цахим хэлбэрээр хадгалах харьяа байгууллагын архивын баримтыг татан авах, төрөлжүүлэх, хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад зориулан хард диск худалдан авахад хөрөнгө гаргасугай.

2.Хард диск худалдан авахад шаардагдах 193,340 (Нэг зуун ерэн гурван мянга гурван зуун дөч) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодлогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажиллахыг Архивын хэлтэс (Н.Өлзийцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 122 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Хард диск	ширхэг	193.340	1	193.340
	Нийт:				193.340